



ЗАВХАН АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/11

Улиастай

Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн  
Эрүүл мэндийн төвүүдэд санхүүгийн  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16.5.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 12.11 дэх заалтууд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02-р сарын 27-ны өдрийн “Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн сумын эрүүл мэндийн төвүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай” А/86 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Монгол улсын нийт нутаг дэвсгэрт өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрч улсын болон эрүүл мэндийн салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуудан зудын нөхцөл байдалд байгаа орон нутгийн иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасралтгүй хэвийн үзүүлэх зорилгоор зудын нөхцөл, байдлын үнэлгээгээр хүндэрсэн сумын эрүүл мэндийн төвүүдийн шатахууны зардалд нэмэлтээр олгох төсвийг хавсралтаар баталсугай.

2. Хуваарилагдсан төсвийг зохих журмын дагуу зарцуулж, санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлэн өр төлбөрийг шийдвэрлэн ажиллахыг сумын Эрүүл мэндийн төвийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийг холбогдох зардлаас зарцуулахыг Ерөнхий санхүүч (Д.Чимэддолгор)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтэс (Ж.Должинсүрэн)-т даалгасугай.

ДАРГА



М.ҮРЖИНХАНД

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны  
..03....дугаар сарын.18...ны өдрийн ..А/А/  
дугаар тушаалын хавсралт

Эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан шатахууны зардал

	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Шатахууны зардал
1	Алдархаан сумын Хүн эмнэлэг	1000000
2	Асгат сумын хүн эмнэлэг	2000000
3	Баянтэс сумын хүн эмнэлэг	2000000
4	Баянхайрхан сумын хүн эмнэлэг	2000000
5	Дөрвөлжин сумын Хүн эмнэлэг	1000000
6	Завханмандал сумын хүн эмнэлэг	1000000
7	Их-уул сумын хүн эмнэлэг	2000000
8	Идэр сумын хүн эмнэлэг	2000000
9	Нөмрөг сумын хүн эмнэлэг	2000000
10	Отгон сумын хүн эмнэлэг	2000000
11	Сантмаргаз сумын хүн эмнэлэг	2000000
12	Сонгино сумын хүн эмнэлэг	2000000
13	Түдэвтэй сумын хүн эмнэлэг	2000000
14	Тэс сумын хүн эмнэлэг	2000000
15	Тэлмэн сумын хүн эмнэлэг	2000000
16	Ургамал сумын хүн эмнэлэг	2000000
17	Цагаанхайрхан сумын хүн эмнэлэг	1000000
18	Цагаанчулуут сумын хүн эмнэлэг	2000000
19	Цэцэн-уул сумын хүн эмнэлэг	2000000
20	Эрдэнэхайрхан сумын хүн эмнэлэг	1000000
21	Шилүүстэй сумын хүн эмнэлэг	2000000
22	Яруу сумын хүн эмнэлэг	1000000
	Нийт	38000000